


СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/15-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хушаат сум
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Аудитор: Т.Мөнхзул
Утас: 70362442 Цахим хаяг: munkhzult@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12
4. Аудитын тайлан	21
4.1 Ерөнхий зүйл.....	21
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	24
5. Аудитын илрүүлэлт	26
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль, орчин аялал жуулчлалын газар
БОАЖЯ	Байгаль, орчин аялал жуулчлалын яам
ГХУССЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗЗНДНТУ	Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

хувийг буюу 245,723.2 мянган төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 30.9 хувийг буюу 341,458.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулсан байна.

Тайлант онд сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төв нь тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд шилжсэнээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



СӨЛӨНГӨ АЙМАГ ДАХЬ
ГОРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХУШААТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.ЗАХИРАХБААТАР ТАНАА

2023.03.25 № 02А 2023/15-НА-СТА-ТТЗ
Танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хушаат сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар 1,560,708.8 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 1,101,527.4 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл 70.6 хувьтай тайлагнагдсан бөгөөд батлагдсан төсвийг 459,181.4 мянган төгрөгөөр буюу 29.4 хувиар хэмнэсэн байна

Аудитын гол асуудал

Хушаат сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 30.2 хувийг буюу 332,689.7 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд, 22.3

СЭА-2023/15-НА-СТА-ТТЗ

018020391

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	439,418.9	539,796.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	180,414.2	237,525.6
33	АВЛАГА	185,002.2	122,988.7
35	БАРАА МАТЕРИАЛ	74,002.5	179,281.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,342,561.8	1,088,419.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,342,561.8	1,088,419.8
39200	Биет хөрөнгө	3,176,026.2	971,537.0
39300	Биет бус хөрөнгө	166,535.6	116,882.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,781,980.7	1,628,215.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,790.7	6,560.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,790.7	6,560.0
41300	Өглөг	6,790.7	6,560.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,775,190.0	1,621,655.8
51	Засгийн газрын хувь оролцоо	3,775,190.0	1,621,655.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,254,868.7	310,470.4
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0	310,470.4
51200	Хуримтлагдсан үр дүн	1,477,149.4	1,150,629.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,043,171.9	160,555.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,781,980.7	1,628,215.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,235,979.8	1,686,267.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	132,312.6	430,379.9
110	Орлогын албан татвар	38,506.9	156,280.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	38,506.9	156,280.3
113	Хөрөнгийн албан татвар	64,640.3	180,399.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	29,165.4	93,699.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	207,403.6	342,132.4
120	Нийтлэг татварын бус орлого	207,403.6	342,132.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,896,263.7	913,755.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,113,540.0	980,033.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,113,540.0	980,033.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,057,248.8	961,487.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,163,861.4	298,026.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,095.8	36,084.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	199,427.5	245,723.2
2104	Хангамж, бараа материалын зардал	67,957.0	51,677.7

2105	Нормативт зардал	108,436.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,236.4	35,436.3
2107	Томилолт, зочны зардал	3,195.9	3,522.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,107.3	33,273.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	312,931.6	257,742.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,2191.2	18,546.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	122,439.8	706,233.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	92,012.6	2,823,890.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	30,427.2	-2,117,656.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,744,762.8	-	3,744,762.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,744,762.8	-	3,744,762.8
4	Тайлант үеийн үр дүн	30,427.2	-	30,427.2
5	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,775,190.0	-	3,775,190.0
6	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,775,190.0	-	3,775,190.0
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-35,877.7	-	-35,877.7
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,739,312.4	-	3,739,312.4
9	Тайлант үеийн үр дүн	-2,117,656.5	-	-2,117,656.5
10	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,621,655.8	-	1,621,655.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,088,664.8	1,397,490.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	132,312.6	430,379.9
110	Орлогын албан татвар	38,506.9	156,280.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	38,506.9	156,280.3
113	Хөрөнгийн албан татвар	64,640.3	180,399.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	29,165.4	93,699.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,787.2	6,729.2

1181	Газрын төлбөр	10,151.1	32,809.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	13,227.1	54,160.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,908.2	42,609.9
120	Нийтлэг татварын бус орлого	64,908.2	42,609.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,891,444.1	924,500.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,860,440.0	786,313.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,860,440.0	786,313.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,801,676.9	767,767.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,165,527.4	298,026.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,700.0	36,398.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	199,527.5	245,723.2
2104	Хангамж, бараа материалын зардал	63,189.8	47,785.2
2105	Нормативт зардал	98,371.7	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,565.3	35,436.3
2107	Томилолт, зочны зардал	3,195.9	3,522.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,303.1	39,887.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,296.1	60,986.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,763.1	18,546.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	228,224.8	611,176.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	125,829.6	554,065.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	125,829.6	554,065.4
2200	Дотоод эх үүсвэрээр	125,829.6	554,065.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-125,829.6	-554,065.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	102,395.3	57,111.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	78,019.0	180,414.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	180,414.2	237,525.6

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,560,708.8	1,101,527.4	459,181.4	70.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	793,043.8	760,069.1	32,974.7	95.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	774,497.3	741,522.6	32,974.7	95.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310,898.1	296,290.8	14,607.3	95.3

210101	Үндсэн цалин	180,192.5	202,019.4	(21,826.9)	112.1
210102	Нэмэгдэл	59,742.6	34,394.7	25,347.9	57.6
210104	Урамшуулал	5,021.2	4,039.7	981.5	80.4
210105	Гэрээт ажлын хөлс	65,941.8	55,837.0	10,104.8	84.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,478.3	36,398.9	2,079.4	94.6
210201	Тэтгэврийн даатгал	26,358.4	25,151.2	1,207.2	95.4
210202	Тэтгэмжийн даатгал	2,512.4	2,754.3	(241.9)	109.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,023.0	2,405.7	617.3	79.6
210204	Ажилгүйдлийн даатгал	598.9	548.2	50.7	91.5
210205	Эрүүл мэндийн даатгал	5,985.6	5,539.5	446.0	92.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	248,802.1	245,723.2	3,078.8	98.7
210301	Гэрэл, цахилгаан	24,183.4	21,306.1	2,877.3	88.1
210302	Түлш, халаалт	220,341.8	220,341.8	0	100
210303	Цэвэр, бохир ус	4,276.9	4,075.3	-201.6	95.3
2104	Хангамж, бараа материалын зардал	44,540.1	44,540.1	0	100
210401	Бичиг хэрэг	8,598.7	8,598.7	0	100
210402	Тээвэр, шатахуун	25,349.5	25,349.5	0	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,851.7	3,851.7	0	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,740.2	6,740.2	0	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,298.8	51,236.3	62.5	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,000.0	11,000.0	0	100
210602	Тавилга	4,800.0	4,800.0	0	100
210604	Урсгал засвар	35,498.8	35,436.3	62.5	99.8
2107	Томилолт, зочны зардал	3,524.5	3,522.3	2.2	99.9
210702	Дотоод албан томилолт	3,524.5	3,522.3	2.2	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,560.0	53,410.9	149.0	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,017.4	53,017.3	0.1	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148.9	-	148.9	0
210803	Даатгалын үйлчилгээ	183.2	183.2	0	100
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	210.5	210.5	0	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,395.4	10,400.0	12,995.4	44.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,395.4	10,400.0	12,995.4	44.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,546.5	18,546.5		
2132	Бусад урсгал шилжүүлэг				
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,966.5	17,966.5	0	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	580.0	580.0	0	100
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	600,351.3	341,458.3	258,893.0	56.9
220001	Барилга байгууламж	352,851.3	230,476.3	122,375.0	65.3
221001	Их засвар	153,000.0	59,400.0	93,600.0	38.8

222001	Тоног төхөөрөмж	25,000.0	25,000.0	0	100
224001	Бусад хөрөнгө	69,500.0	26,582.0	42,918.0	38.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	167,313.7	0	(167,313.7)	0
230001	Эргэж төлөгдөх зээл	167,313.7	0	(167,313.7)	0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,560,708.8	1,189,690.6	371,018.2	76.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,372,417.6	1,163,471.1	208,946.5	84.8
320001	Орон нутгийн төсвөөс	1,203,535.4	994,588.8	208,946.5	82.6
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	168,882.2	168,882.2	0	100
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	188,291.2	26,219.5	162,071.5	13.9
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	106,729.0	26,219.5	80,509.5	24.6
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	81,562.2	-	81,562.2	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	88,616.3	(88,616.3)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	176,779.5	(176,779.5)	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	244,379.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70,263.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,735.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,736.0
210104	Урамшуулал	1,736.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,245.0
210401	Бичиг хэрэг	455.0
210402	Тээвэр, шатахуун	2,760.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,654.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,527.8
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,527.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	174,116.0
2200	Дотоод эх үүсвэрээр	174,116.0
220001	Барилга байгууламж	174,116.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	243,279.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	243,279.6
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-1,100.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,100.0

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хушаат сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хамтдаа хэлэлцэж хөгжлийн гарцаа нээе. Хамтдаа шийдэж иргэнээ, өрх гэрээ, орон нутгаа хөгжүүлье” гэж тодорхойлсон байна.

Дээрх дэвшүүлсэн зорилт арга хэмжээний хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн ажил үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг хангах,
- Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх,
- Төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж, иргэдийн оролцоог хангаж хамтран ажиллах,
- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2022 оны 194 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт”-д өөрчлөлт оруулсан,
- Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлөгдөх, хяналт тавих журамд ХХААХҮ-ийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 26-ны А/243 тушаалаар журамд нэмэлт өөрчлөлт оруулсан гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хушаат сумын ТТЗ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хушаат сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “*Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг*”- ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хушаат сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “*Төсвийн ерөнхийлөн*

захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,153,764.8 мянган төгрөгөөр буюу 57 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	180,414.2	237,525.6	57,111.4
Авлага	185,002.2	122,988.7	(62,013.5)
Бараа материал	74,002.5	179,281.8	105,279.3
Үндсэн хөрөнгө	3,342,561.8	1,088,419.8	(2,254,142.0)
Нийт хөрөнгө	3,781,980.7	1,628,215.9	(2,153,764.8)
Өр төлбөр	6,790.7	6,560.0	(230.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,775,190.0	1,621,655.9	(2,153,534.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,781,980.7	1,628,215.9	(2,153,764.8)

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данс байгаа бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 237,525.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 57,111.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	180,414.2	237,525.6	57,111.40
Төгрөг	180,414.2	237,525.6	57,111.40
Төрийн сангийн харилцах	180,414.2	237,525.6	57,111.40
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Дүн	180,414.2	237,525.6	57,111.40

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд тайлагнагдсан орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 60,746.1 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 69,925.8 мянган төгрөг, хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 106,853.7 мянган төгрөг тус тус байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын ЗДТГ нь 4,122.4 мянган төгрөгийн бэлэн мөнгөний хөдлөл өөрчлөлт, зарцуулалтын тайлан гараагүй.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 122,988.7 мянган төгрөг болж, өмнөх оноос мянган 62,013.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	1,607.7	365.9	(1,241.8)
Татаас, санхүүжилтийн авлага	6,091.1	0	(6,091.1)
Зээлийн хүүгийн авлага	7,480.8	7,480.8	0
Байгууллагаас авах авлага	28,461.1	0	(28,461.1)
Хувь хүмүүсээс авах авлага	33,940.2	31,790.2	(2,150.0)
Хувь хүмүүст олгосон зээл	107,421.3	83,351.8	(24,069.5)
Дүн	185,002.2	122,988.7	(62,013.5)

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл 122,988.7 мянган төгрөг болсон нь ИТХ, ЗДТГ-ын НДШ-ийн авлага 1,241.8 мянган төгрөгөөр, татаас санхүүжилтийн авлага 6,091.1 мянган төгрөгөөр, хувь хүмүүсээс авах авлага 2,150.0 мянган төгрөгөөр, хувь хүмүүст олгосон зээл 24,069.5 мянган төгрөгөөр буурч, бүтцийн өөрчлөлтөөр 28,461.1 мянган төгрөгийн авлага холбогдох яамдад шилжсэнтэй тус тус холбоотой байна.

Насжилт өндөртэй /3-аас дээш жил/ зээлийн авлагыг барагдуулахаар холбогдох шатны шүүхэд хандаж 13 иргэний нийт 83,351.8 мянган төгрөгийн нэхэмжлэлийг хүргүүлж, 7 иргэнийг ШШГТ-т шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын ЗДТГ, ИТХ нь төлбөр тооцоог хянаагүйгээс НДШ-ийн 1,241.8 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 179,281.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 105,279.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	2,223.8	0	(2,223.8)
Эм боох материал	4,151.7	0	(4,151.7)
Бэлэн бүтээгдэхүүн	9,553.5	0	(9,553.5)
Бичиг хэргийн материал	1,253.6	457.0	(796.6)
Аж ахуйн материал	25,574.5	736.0	(24,838.5)
Сэлбэг хэрэгсэл	630.0	0	(630)
Барилгын засварын материал	662.8	0	(662.8)
Хүнсний материал	6,942.1	0	(6,942.1)

Бусад хангамжийн материал	23,010.5	178,088.8	155,078.30
Дүн	74,002.5	179,281.8	105,279.3

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оныхоос 105,279.3 мянган төгрөгөөр өссөн нь 356,881.3 мянган төгрөгийн материал худалдан авсан, 94,582.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан болон 123,028.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, ОНХС-аар хийгдсэн ажлуудын 164,238.2 мянган төгрөгийн бараа материалыг ашиглагч байгууллагуудад шилжүүлж, сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төвүүд тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчид харьяалагдах болж 58,916.9 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

ИТХ нь 3,540.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл анхны өртгөөр 1,710,915.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,456,652.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,000,224.1	1,594,012.5	(2,406,211.5)
Барилга, байгууламж, орон сууц	2,216,340.6	553,692.7	(1,662,647.8)
Авто-тээврийн хэрэгсэл	232,803.1	156,229.2	(76,573.9)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	253,531.3	116,335.1	(137,196.2)
Тавилга, аж ахуйн эд хогшил	145,709.6	36,209.2	(109,500.4)
Зам, гүүрийн байгууламж	231,458.6	230,042.8	(1,415.8)
Бусад үндсэн хөрөнгө	343,078.1	331,379.5	(11,698.6)
Дуусаагүй барилга, байгууламж	484,579.0	100,124.0	(384,455.0)
Ном	92,723.8	70,000.0	(22,723.8)
Биет бус хөрөнгө	167,343.4	116,882.8	(50,460.6)
Программ хангамж	850.0	0	(850.0)
Бусад биет бус хөрөнгө	166,493.4	116,882.8	(49,610.6)
Дүн	4,167,567.5	1,710,895.3	(2,456,672.1)

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл / анхны өртгөөр / 1,710,895.3 мянган төгрөг болж өмнөх оноос 2,456,672.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр машин тоног төхөөрөмж, тавилга 38,471.3 мянган төгрөгөөр худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 229,010.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, 2,724,153.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр холбогдох ерөнхийлөн захирагчдад шилжүүлснээс голлон шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 35 нэр

төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 6,560.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 230.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	6,790.7	6,560.0	(230.7)
Дүн	6,790.7	6,560.0	(230.7)

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 6,560.0 мянган төгрөг байгаа нь ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн 8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй камержуулалтын ажлын 20 хувийн санхүүжилтийн 1,600.0 мянган төгрөгийн өглөг, сум хөгжүүлэх сангийн / ХХС / 2012 оны 4,960.0 мянган төгрөгийн өглөг барагдаагүйтэй холбоотой байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,621,655.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,153,534.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,254,868.7	310,470.4	(944,398.3)
Өмнөх үеийн үр дүн	1,446,722.2	3,268,286.2	1,821,564.0
Тайлант үеийн үр дүн	30,427.2	(2,117,656.5)	(2,148,083.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,043,171.9	160,555.8	(882,616.1)
Дүн	3,775,190.0	1,621,655.9	(2,153,534.1)

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,621,655.9 мянган төгрөг болж 2,153,534.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

3.4.7 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 23,344.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Иргэдийн Төлөөлөгчийн Хурал:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 06 тоот тогтоолоор 3 сургалт зохион байгуулахаар шийдвэрлэж, 1,433.5 мянган төгрөг зарцуулсан боловч

эдгээр нь төсвийн тооцоо, сургалтын хөтөлбөр, гүйцэтгэлийн тайлан зэрэг анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Засаг даргын Тамгын газар:

- Албан хаагчдын илүү цагийн нэмэгдэл хөлсний тооцоог “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар баталгаажуулалгүйгээр 4,484.5 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон,
- Төсвийн тооцоо, ажил гүйцэтгэх гэрээ, ажил хүлээн авсан акт зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр байрны засвар 12,184.0 мянган төгрөг, дотоод сүлжээ тавиулахад 1,882,4 мянган төгрөг зэрэг нийт 14,066.4 мянган төгрөг зарцуулсан байна.
- Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын ЗДТГ-ын авто машины засвар, сэлбэг хэрэгсэлд 3,359,9 мянган төгрөгийг зарцуулж, зориулалт бусаар зарцуулсан байна.
- Шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсаар баталгаажуулахдаа спидометрийн эхний, эцсийн заалт, зарцуулсан шатахуун, явсан км зэргийг бүртгээгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 25 хөтөлбөрт зориулан 1,560,708.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 793,043.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 600,351.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 167,313.7 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөгдөх зээл, үйл ажиллагааны зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 517,853.5 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, орон нутгийн төсвийн орлогоос 446,770.2 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг 168,882.2 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 21,863.1 мянган төгрөг, ОНХС-ийн эхний үлдэгдэл 7,882.1 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн орлого 99,899.6 мянган төгрөгийн зэрэг нийт 1,263,150.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,101,527.4 мянган төгрөг буюу 70.6 хувьтай тайлагнагдсан нь ХХС-аас зээл олгоогүй, ТШЗ-д орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 14,607.3 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардал 2,079.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,078.8 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 62.5 мянган төгрөгөөр, томилолтын зардал 2.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил,

үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 149.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 12,995.4 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 258,893.0 мянган төгрөг, эргэн төлөгдөх зээл 167,313.7 мянган төгрөгөөр нийт 459,181.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар нийт 13 төсөл, арга хэмжээнд 600,351.3 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 411,384.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.5.2 Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Хушаат сумын ИТХ-ын “2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 22 дугаар тогтоолоор 648,818.8 мянган төгрөгийн татварын орлого, 15,000.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 446,770.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 32.7 хувиар буюу 217,048.6 мянган төгрөгөөр тасалсан нь малын тоо толгойн албан татвар 250,508.8 мянган төгрөгөөр тасарсантай холбоотой байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	648,818.8	430,379.9	238,438.90	66.3
Үйл ажиллагааны орлого	16,000.0	15,734.7	265.30	98.0
Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого	85,000.0	121,864.1	(36,864.1)	143.3
Хөрөнгийн орлого	13,000.0	15,419.9	(2,419.9)	118.6
Хөрөнгө борлуулсны орлого	3,000.0	3,261.6	(261.6)	108.7
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	8,800.0	5,611.7	3,188.3	64
Бууны албан татвар	1,100.0	1,710.0	(610)	156
Малд ногдуулах албан татвар	423,587.0	173,078.2	250,508.8	41
Улсын тэмдэгтийн хураамж	3,000.0	2,138.2	861.8	72
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	150.0	500.0	(350)	333.34
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,600.0	4,091.0	2509	62
Газрын төлбөр	25,808.0	30,109.9	(4,301.9)	117
Дуудлага худалдаа	20,519.0	2,700.0	17,819	14
Ойн нөөц ашигласны төлбөр	40,686.8	48,110.4	(7,423.6)	119
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,268.0	1,080.0	188	86
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	300.0	4,970.2	(4,670.2)	1657
Татварын бус орлого	15,000.0	16,390.3	(1,390.3)	109.3
Торгуулийн орлого	5,000.0	495.0	4,505	10
Бусад орлого	10,000.0	15,895.3	(5,895.3)	159
Нийт орлогын дүн	663,818.8	446,770.20	217,048.60	67.3

Эх сурвалж: Хушаат сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд ХХОАТ-ын орлого, газрын төлбөр, байгалийн ургамал ашигласны төлбөр, бусад орлого тус тус давж биелсэн байна.

Малын тоо толгойн албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, хүү, торгуулийн орлого тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **ХХОАТ-ын орлого:** Засгийн газрын 2022 оны 107, 192, 194 дүгээр тогтоолуудаар төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор цалин хөлс, шагнал, урамшуулал болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутган тооцох татварын орлого нэмэгдэж, 57,532.7 мянган төгрөгөөр,
- **Газрын төлбөр:** Тайлант онд газар эзэмших болон ашиглах бүртгэл шинэчлэн хийснээс иргэд урьд онуудын нэхэмжилсэн төлбөрөө барагдуулснаас,
- **Байгалийн ургамал ашигласны төлбөр:** Бэлчээр болон хадлан сайн ургаж иргэд төлбөр хураамжаа сайн төлснөөс, тус тус орлогууд давж биелсэн байна.

Тасарсан орлогууд:

- **Малын тоо толгойн албан татвар:** 2021 онд малын хөлийн татвар төлөвлөөгүй гэх үндэслэлээр 2022 онд өмнөх оны төлөвлөгөөг давхар төлөвлөснөөс шалтгаалан орлого тасарсан байна.
- **Хог хаягдлын үйлчилгээний хураамж:** Иргэдийн орлого багасаж, өрхүүд хог хаягдлын төлбөрөө гүйцэд төлөөгүйгээс шалтгаалсан байна.
- **Хүү, торгуулийн орлого:** Орлогыг тооцоо судалгаа муутай төлөвлөснөөс шалтгаалан тасарсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд сумын төсөвт 3 удаа тодотгол хийсэн байна. Үүнд:

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн төсөв батлах тухай 16 дугаар тогтоолоор:

- Татварын болон татварын бус орлогыг 230,231.8 мянган төгрөг,
- Аймгаас суманд олгох санхүүгийн дэмжлэг 560,881.3 мянган төгрөг,
- Урьд оны үлдэгдлээс 10,850.9 мянган төгрөг,
- Орон нутгийн хөгжлийн сангийн эхний үлдэгдэл 7,882.1 мянган төгрөг,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 168,882.2 мянган төгрөг,
- ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 180,409.1 мянган төгрөг, нийт **1,159,137.4** мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн тодотгосон төсөв батлах 11 дүгээр тогтоолоор:

- Малын тоо толгойн албан татварыг өмнөх онд төлөвлөөгүйгээс 423,587.0 мянган төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 30,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн татварын болон татварын бус орлогыг 683,818.8 мянган төгрөгөөр,
- Аймгаас суманд олгох санхүүгийн дэмжлэгийг 560,881.3 мянган төгрөгөөр,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 168,882.2 мянган төгрөгөөр,
- Орон нутгийн эхний үлдэгдлийг 11,012.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 21,863.1 мянган төгрөгөөр ,
- Орон нутгийн хөгжлийн сангийн эхний үлдэгдлийг 7,882.1 мянган төгрөгөөр,
- ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 180,409.1 мянган төгрөгийг зэрэг нийт 1,623,736.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 55 дугаар тогтоолоор аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг 43,027.8 мянган төгрөгөөр бууруулсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2022 оны 11 дүгээр сарын 07–ны өдрийн 22 дугаар тогтоолоор:

- Татварын болон татварын бус орлогыг 20,000.0 мянган төгрөгөөр бууруулан 663,818.8 мянган төгрөгөөр,
- Урьд оны үлдэгдлээс 21,863.1 мянган төгрөг,
- Орон нутгийн хөгжлийн сангийн эхний үлдэгдэл 7,882.1 мянган төгрөг,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 168,882.2 мянган төгрөгөөр,
- Аймгаас суманд олгох санхүүгийн дэмжлэгийг 517,853.5 мянган төгрөгөөр,
- ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 180,409.1 мянган төгрөг зэрэг нийт 1,560,708.8 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ЗДНХ-өөс 2,418.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчдаас 232,701.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 8,159.5 мянган төгрөг зэрэг нийт 243,279.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 1,736.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 3,245.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 6,100.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 53,654.6 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 174,116.1 мянган төгрөг зэрэг нийт **244,379.5** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хушаат сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэх, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгэх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хушаат сумын ТТЗ нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/18 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 2,793,090.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 27,930.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан ЕБС, цэцэрлэг, ЭМТ, соёлын төв зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлан тус тусын яаманд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого болох 1,686,267,5 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон 16,862.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/633 дугаар

албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт нийт 18 төрлийн чиглэлийг хүргүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 14,607.3 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчийн НДШ-ийн зардал 2,079.4 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,078.8 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардал 12,995.4 мянган төгрөгөөр,
- Хөрөнгийн зардал 258,893.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтуудыг зөрчсөн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

1.Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	155	130	19	6
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151	135	14	2
3	Засаг даргын Тамгын газар	151	134	13	4
	Нийт дүн	457	399	46	12

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Сумын ОНХС-ийн төлөвлөгөөнд малын хулгайтай тэмцэх гэх үндэслэлээр улсын төсөвт байгууллагын ажилтан болох "Хэсгийн цагдааг унаажуулах" төсөл, арга хэмжээнд 25,000 мянган төгрөг төлөвлөж, Prius маркын авто машин худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно", 60.3.1: "Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах зөвлөмж өгөх.

2. Сумын баяр наадмын 5,000.0 мянган төгрөгийн төсвийг ОНХС-ийн төсөвт бус ЗДТГ-ын төсөвт тусган санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно, 60.3.3: "Үндэсний их баяр наадмаас бусад баяр наадам, ойн арга хэмжээ..." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баяр наадмын зардлыг ОНХС-ийн төсөвт тусган, баталж байх зөвлөмж өгөв. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ болон сумын баяр наадмын зардлын төлөвлөлт нь Төсвийн тухай хуультай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн тодотгол, өглөг авлага үүсгэсэн, анхан шатны баримтын бүрдүүлэлт, төлбөрийн цахим баримт, шилэн данстай холбоотой нийт 74,998.6 мянган төгрөгийн 9 зөрчилд албан шаардлага, СЭА-2023/15-НА-СТА-ТТЗ

зөвлөмж өгөгдсөнөөс, авлага үүсгэхгүй ажиллах, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд үнэн зөв тусгаж байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	5	30,216.0	4	28,962.9	80.0
Зөвлөмж	4	44,782.6	3	39,603.8	75.0
Нийт дүн	9	74,998.6	7	73,514.8	77.8

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр бараа материалын худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн Б/29 дүгээр захирамжаар 2021 оны санхүүгийн тайланг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр сумын Санхүүгийн албаны дарга О.Цогбаярт үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж олгох шийдвэрийг үндэслэн 1,386.6 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Малын тоо толгойн албан татварын орлогыг 2021 онд төлөвлөөгүй гэх үндэслэлээр 2022 онд 2 жилийг нийлүүлэн 423,587.0 мянган төгрөгөөр үндэслэлгүй төлөвлөснөөс шалтгаалан төлөвлөгөөг 250,508.8 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална.”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн тул цаашид төсвийн орлогыг бодит байдалд үндэслэн үнэн зөв төлөвлөж байх нь зүйтэй юм.

3. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг шалгаж амжаагүй тул Улс, орон нутгийн

төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай.

4.Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн авлагад 83,351,8 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас 2011-2015 онд олгосон 13 иргэний 83,351.8 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг холбогдох шатны шүүхэд хандаж бүрэн шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ:

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт 33,065.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 13,080.8 мянган төгрөгийн албан шаардлага, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 19,984.4 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлэв.

5.1 Албан шаардлага

1.Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй буюу, төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас дараах байгууллагууд нь НДШ-ийн нийт 1,241.8 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна. Үүнд:

- ИТХ нь 365.8 мянган төгрөгийн,
- ЗДТГ нь 876,0 мянган төгрөгийн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2.ИТХ нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй нийт 3,540.0 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгасан буюу зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

ЗДТГ:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Нягтлан бодогч Н.Нямжаргалд ЗДТГ-ын даргын 2022 оны 9 сарын 01-ний өдрийн Б/18 дугаар тушаалаар санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт авсан гэх үндэслэлээр 1,196.5 мянган төгрөг, жилийн эцэст улирлын ажлын үр дүнгийн урамшуулал 319.0 мянган төгрөг зэрэг нийт 1,515.5 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь тогтоосон хэмжээнээс **293.3** мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтаар баталсан *“Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

4.Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс ЗДТГ-ын авто машины засвар, үйлчилгээнд **3,883,3** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь *“Энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

5. Сумын ЗДТГ-ын 4,122.4 мянган төгрөгийн бэлэн мөнгөний хөдлөл, өөрчлөлт, зарцуулалтын тайлан гаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх *“Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ... хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг тухай бүр бүртгэж, бэлэн мөнгөний тайлан гаргаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэлгүй дараах 19,984.4 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- ИТХ нь ГХУСААЗ-аас төсвийн тооцоо, сургалтын хөтөлбөр, гүйцэтгэлийн тайлан зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 3 сургалтын 1,433.5 мянган төгрөг,
- ЗДТГ нь төсвийн тооцоо, ажил гүйцэтгэх гэрээ, ажил хүлээн авсан акт зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр байрны засварт 12,184.0 мянган төгрөг, дотоод сүлжээ тавиулахад 1,882,4 мянган төгрөг, илүү цагийн нэмэгдэл хөлсний тооцоог “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар баталгаажуулалгүйгээр 4,484.5 мянган төгрөг, спидометрийн заалт, явсан км, хариуцсан албан тушаалны нэр зэрэг нь бичигдээгүй жолоочийн тооцооны хуудсаар шатахуун зарцуулсан зэрэг нийт 18,550,9 мянган төгрөг.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд болон Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.4 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

2.Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 35 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ												
ИТХ	3	5,339.3			2	3,905.8	1	1,433.5				
ЗДТГ	6	27,725.9			4	9,175.0	2	18,550.9				
Дүн	9	33,065.2			6	13,080.8	3	19,984.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ19 мэдээллийг хоцроож, 6 мэдээллийг мэдээлээгүй	25				25			
ИТХ 14 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй	16				16			
ЗДТГ 13 мэдээллийг хоцроож, 4 мэдээллийг мэдээлээгүй	17				17			
Дүн	58				58			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ОНХС-ийн хөрөнгийг зориулалт	1	25,000.0					1	25,000.0

бусаар зарцуулсан								
Баяр наадмын зардлыг ЗДТГ-ын төсөвт баталсан	1	5,000.0					1	5,000.0
Дүн	2	30,000.0					2	30,000.0
Нийт дүн	60	30,000.0			58		2	30,000.0